


ГЯЛС БАНК

ВЭБЭЭР ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ 

- ▶ ХАРИЛЦАГЧДАД
ЗОРИУЛСАН
ГАРЫН АВЛАГА



АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨМЖ

1. Нууц үгийн аюулгүй байдлыг хангах:

Интернэт банкны нэвтрэх нэр, нууц үгээ бусдад задруулахгүй байх, тогтмол хугацаанд сольж хэвших. Өөрийн болон гэр бүлийн гишүүдийн нэр, төрсөн огноо, гар утасны дугаар гэх мэт бусад хүмүүс амархан таамаглах боломжтой мэдээллийг нууц үг болгон ашиглахгүй байх. Нууц үг нь 12-с дээш тэмдэгттэй бөгөөд Том үсэг, жижиг үсэг, тоо, тэмдэгт агуулсан байх нь илүү найдвартай байдгийг анхаарч хүчтэй нууц үг үүсгэн ашиглахыг зөвлөж байна.

2. Нууц үгийн ашиглалт: Интернэт банкны нууц үгийг бусад системд болон социал сүлжээ, цахим шуудан гэх мэт бусад ашигладаг нууц үгтэй давхардуулахгүй байх. Мөн нэвтрэх нэр, нууц үгийг веб хөтөч дээрээ сануулж, хадгалахгүй байх.

3. Давхар танин баталгаажуулалт:

Two Factor Authentication буюу давхар танин баталгаажуулалтыг интернэт банк, социал хаяг, хувийн и-мэйл хаягтаа нэмэлт тохиргоо хийн идэвхжүүлэж, нэвтрэх нууц үгээс гадна давхар баталгаажуулах код оруулан аюулгүй байдлаа сайжруулаарай.

4. Төхөөрөмжийн баталгаажуулалт:

Интернэт банканд тогтмол хандах төхөөрөмжөө баталгаажуулж нэвтэрсэн төхөөрөмжийн жагсаалтаас бүртгэлээ тогтмол хянаж аюулгүй байдлаа хангаарай.

5. Мэдээлэл шинэчлэх:

Хэрэв харилцагч таны бүртгэлтэй утасны дугаар өөрчлөгдсөн бол өөрт ойрхон Төрийн банкны салбар нэгж дээр яаралтай очин хувийн мэдээллээ шинэчлүүлэх.

6. Фишинг и-мэйлээс сэргийлэх: Интернэт банкны нэвтрэх мэдээлэл болон бусад хувийн мэдээллийг хулгайлах зорилготой, банкны нэрийн өмнөөс хуурамч и-мэйл илгээх цахим гэмт хэрэг түгээмэл байдаг. Иймээс хуурамч холбоос болон сэжигтэй хавсралт файл агуулсан фишинг и-мэйлээс сэргийлэх, тэдгээрийг таньж сурах, Хэрвээ сэжигтэй и-мэйл хүлээн авсан бол Төрийн банкны 1800-1881 дугаараар эсвэл contact@statebank.mn хаягаар яаралтай мэдэгдэх.

7. Дансаа тогтмол хянах:

Дансны хуулгаа тогтмол хянаж, сэжигтэй болон зөвшөөрөлгүй гүйлгээг нэн даруй мэдээлэх. Мөн дансны орлого, зарлагын мэдээллийг цахим шуудан эсвэл мессежээр хянаж байх.

8. Аюулгүй төхөөрөмж ашиглах:

Олон нийтийн үнэгүй Wi-Fi эсвэл үйлчилгээний газрын баталгаагүй дундын компьютер ашиглан интернэт банканд холбогдохоос зайлс хийх, Интернэт банк ашиглахдаа <https://> буюу SSL нууцлалын сертификатаар хамгаалагдсан эсэхийг хянах.


ВЭБЭЭР ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ



Та интернэт ашиглан Төрийн банкны www.statebank.mn вэб хуудасны ГЯЛСБАНК холбоосоор дамжуулан мөн www.gyalsweb.statebank.mn холбоосоор хандан дараах үйлчилгээг авах боломжтой.

The screenshot displays the Gyalsbank website interface. At the top, there is a navigation bar with links for "Иргэд", "Байгууллага", and "Хувицаа эзэмшигчид". The main header features the "ТӨРИЙН БАНК" logo and navigation buttons for "Сугалаа шалгах", "Бүтээгдэхүүн", and "Бидний тухай". The central content area is titled "и-биллинг" and "и-биллингийн үйлчилгээ". It includes a login form with a "Нэвтрэх нэр" field and a "Нэвтрэх" button. Below the form, there are links for "Гарын авлага", "Нууц үг сэргээх", and "Гялс Банкны хэрэглэгч болох". To the right, there is a list of services: "Бүх банкны картаар төлөх боломжтой", "Бүх банкны харилцагч QIИ кодоор төлөх боломжтой", and "НӨАТУС Ebarimt-н хялбар бүртгэлд бүртгүүлэн E-БАРИМТ авах боломжтой". A QR code is shown on a smartphone screen. At the bottom, there is a navigation bar with icons for "ЦАХИМ БАНК", "ОНЛАЙН ҮЙЛЧИЛГЭЭ", "ХЭРЭГЛЭЭНИЙ ТӨЛӨВ", "ДААТГАЛ", and "КАРТ".


МИНИЙ БҮРТГЭЛ



Харилцагчийн цонх дээр “Миний бүртгэл” цонх харагдана.


Та энэхүү цэсээр дамжуулан хувийн мэдээлэл шинэчлэх, нэвтрэх нууц үг солих, Dark mode, хэл солих, баталгаажсан төхөрөмжүүд болон хандалтын түүх, шинэ төхөөрөмжөөс хандах баталгаажуулах код авах, Two factor authentication буюу давхар баталгаажуулалтад бүртгүүлэх боломжтой.

ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ




Та хувийн мэдээлэл цэсээр дамжуулан банкинд дээр бүртгэлтэй өөрийн мэдээллийг лавлаж харах боломжтой ба нэвтрэх нэр солих, и-мэйл хаяг солих, гэрийн хаяг солих мөн нэг удаагийн нууц үг авах төрлөө солих боломжтой.

НУУЦ ҮГ СОЛИХ




Миний бүртгэл цэсний НУУЦ ҮГ СОЛИХ цэсээр дамжуулан та нэвтрэх нууц үгээ солих боломжтой.

ХАНДАЛТУУД



Миний бүртгэл цэсний ХАНДАЛТУУД цэсээр дамжуулан таны өмнө хандсан төхөөрөмжийн мэдээлэл хандалтын түүх хэсэгт гарах ба мөн таны зөвшөөрөгдсөн төхөөрөмжүүд мэдээлэл харагдах ба та төхөөрөмжөө энэ цэсээр дамжуулан салгах боломжтой.

БАТАЛГААЖУУЛАХ КОД



Миний бүртгэл цэсний БАТАЛГААЖУУЛАХ КОД цэсээр дамжуулан шинэ төхөөрөмжөөс хандах бол энэхүү цэсээр дамжуулан нэг удаагийн код үүсгэн шинэ төхөөрөмжөө баталгаажуулах боломжтой.

ДАНС

> ДАНСНЫ ЖАГСААЛТ

Харилцах данс	дансны дугаар	битүүмжилсэн дүн	боломжит үлдэгдэл
ИРГЭДИЙН ЭНГИЙН ХАРИЛЦАХ ДАНС	MN06003434 9704	0.00 MNT	999,300MNT
БАНКНЫ АЖИЛЧДИН ЦАЛИНГИЙН КАРТ	MN25003434 3446	0.00 MNT	333.02MNT
ЭНГИЙН ХУГАЦААГУЙ ХАДГАЛАМЖ	MN27003410 3378	0.00 MNT	30MNT
ИРГЭДИЙН ЭНГИЙН ХАРИЛЦАХ ДАНС	MN43003434 3717	0.00 MNT	36USD
ЭНГИЙН ХУГАЦААГУЙ ХАДГАЛАМЖ	MN66003410 960	0.00 MNT	25USD
ЭНГИЙН ХУГАЦААГУЙ ХАДГАЛАМЖ	MN89003410 3740	0.00 MNT	30MNT

Хадгаланжийн данс	дансны дугаар	битүүмжилсэн дүн	боломжит үлдэгдэл
ИРГЭДИЙН ХҮҮ-ТАЙ ХАД-Ж 370-730 ХОНОГ	MN66003410 3225	2,62 MNT	2,63 MNT
АЖИЛТНЫ ХУРИМТЛАЛЫН ХАДГАЛАМЖ /MNT/	MN84003434 8451	3 MNT	1,7 MNT

Данс цэсийг сонгох үед таны бүх дансны мэдээлэл харагдана.

Дансны мэдээлэлд тухайн бүтээгдэхүүний дансны мэдээлэл болон битүүмжийн дүн, боломжит үлдэгдлийг мэдээллүүд харагдана.

Сонгосон дансны ард байрлах энэхүү цэсээр дамжуулан дансны хуулга авах болон дансны дэлгэрэнгүй харах боломжтой.

ДАНСНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

Хуулга харах Карт захиалах Гүйлгээ хийх


Сүүлийн гүйлгээ Хулгагдаж буй

Дансны жагсаалтын дэлгэцээс дансны дэлгэрэнгүй арын товчийг дарж тухайн дансны дэлгэрэнгүй мэдээллийг харах боломжтой.

Дансны тохиргоо болон дэлгэрэнгүй харах

Тухайн дансны хуулга харах, дансанд карт захиалах, гүйлгээ хийх бол дэд цэснээс сонголт хийх боломжтой. Мөн тухайн дансны сүүлийн гүйлгээнүүд харагдана.


ДАНСНЫ ТОХИРГОО



Дансны тохиргоо хэсгээр дамжуулан дансаа удирдах боломжтой.

- **Данс хасах** - Дансны жагсаалтаас хасах бол идэвхгүй болгоно.
- **Гүйлгээний тохиргоо** - Уг дансаар гүйлгээ хийх эсэхийг идэвхжүүлнэ.
- **Дансны нэр солих** - Дансанд дурын нэр өгөх боломжтой.
- **Үндсэн данс болгох** - Нүүр дэлгэц дээр харах сонголтыг хийнэ.
- **Данс хаах** - Данс хаах бол сонголтыг хийж дансыг хаах боломжтой.


ДАНСНЫ ХУУЛГА



Дансны жагсаалтын дэлгэцээс хуулга авах арын товчийг дарж тухайн дансны хуулгыг авна.


Дансны хуулгаа:
Файлаар авч хадгалах,
Жич: Хэвлэж авах тохиолдолд Export to PDF, XLS хэлбэрийн аль нэгийг сонгоно.

ДАНСНЫ НЭМЭХ




Нэмэх данс сонголтыг хийснээр дансны жагсаалт дотор байхгүй дансууд харагдах ба жагсаалт дотор нэмэх бол тухайн дансыг идэвхжүүлнэ.

ДАНС ШИНЭЭР НЭЭХ




Шинээр дараах бүтээгдэхүүнийг бүх валютаар нээх боломжтой:

- Энгийн харилцах данс
- Энгийн хугацаагүй хадгаламж
- Иргэдийн хугацаатай хадгаламж
- Хүүгээр арвижих хугацаатай хадгаламж
- Хуримтлалын хадгаламж



Шинээр нээх дансны бүтээгдэхүүнээ сонгон тухайн дансны валютыг сонгон, үлдэгдэл шилжүүлэх дансаа сонгож, гэрээтэй танилцан үргэжлүүлэх товч дарж нууц үгээ оруулснаар шинээр данс амжилттай нээгдэнэ.

ХАДГАЛАМЖИНД ШИЛЖҮҮЛЭХ



Таны хугацаатай хадгаламжийн хугацаа дууссан бол уг цэсээр дамжуулан дансаа хугацаатай хадгаламж болгох боломжтой.

Дансны дэлгэрэнгүй цэсээс ХАДГАЛАМЖ БОЛГОХ цэсийг сонгоно.

ХАДГАЛАМЖ ЦУЦЛАХ

Сайн байна уу? ЭР. [REDACTED] СҮРЭН

Хадгаламж цуцлах

- Дансны дугаар MN84C [REDACTED] 0004128451
- Бүтээгдэхүүний нэр АЖ [REDACTED] /НТ/
- Дуусах огноо 2024-09-06
- Хүү 12.3
- Хадгаламж цуцлах хүү 2.4
- Шилжжэ бүтээгдэхүүн DR22126000 - ХУГАЦААГУЙ ХАДГАЛАМЖ - ИРГЭН

Хадгаламж цуцлах

Дансны дэлгэрэнгүй цэсний тохиргооноос ХАДГАЛАМЖ ЦУЦЛАХ цэсийг сонгоно.

Цуцлах хадгаламжийн дансны дугаар, бүтээгдэхүүний мэдээлэл, дуусах хугацаа, хадгаламжийн хүүний мэдээлэл харагдана. Хадгаламжийн хүүг цуцлах хүү болон тухайн хадгаламжийн үлдэгдэл шилжүүлэх бүтээгдэхүүний мэдээлэл харагдана.

Хадгаламж цуцлах товчийг дарж баталгаажуулалт хийснээр хадгаламж цуцлагдана.

ДАНС ХААХ

Сайн байна уу? ЭРДЭ [REDACTED] ҮРЭН

Данс хаах

- Овог, нэр ЭРДЭ [REDACTED] ЭНЭ
- Дансны дугаар MNC [REDACTED] 34
- Бүтээгдэхүүний нэр ИРГЭДИЙН ЭНГИЙН ХАРИЛЦАХ ДАНС
- Хуримтлагдсан хүү
- Хүүний хувь
- Дансны үлдэгдэл 99 [REDACTED]
- Данс нээсэн салбар БАНКНЫ ТӨВ
- Дансны битүүмж

* Доод үлдэгдэл шилжүүлэх данс

Данс хаах


Дансны дэлгэрэнгүй цэсний тохиргооноос ДАНС ХААХ цэсийг сонгоно.

Хаах дансны дугаар, бүтээгдэхүүний мэдээлэл, дансны үлдэгдлийн мэдээлэл харагдана.

Доод үлдэгдэл шилжүүлэх дансны дугаараа сонгон данс хаах товчийг дарна.


Нууц үгээ оруулан баталгаажуулалт хийснээр данс хаагдана.

ГҮЙЛГЭЭ



Гүйлгээ хийхэд нэвтрэх нууц үг болон нэг удаагийн нууц үг ашиглана. Нэг удаагийн нууц үгийг доорх 3 хэлбэрээр авах боломжтой. Үүнд:

- И-мэйлээр авах /Банк таны и-мэйл хаягт илгээх/
- Мессежээр авах /Банк таны утасны дугаарт илгээх/
- Васко төхөөрөмж ашиглах



Гүйлгээ цэсээр дамжуулан та дараах гүйлгээнүүдийг хийх боломжтой. Үүнд:

- Банк хооронд
- Банк дотор
- Өөрийн данс хооронд
- Олон улс хооронд
- Гүйлгээний загвар
- Кредит картын төлбөр
- Зээл төлөх
- Цахим төгрөг илгээх
- Багц гүйлгээ

ӨӨРИЙН ДАНС ХООРОНД

Гүйлгээ

Гүйлгээний төрөл

- Өөрийн данс хооронд >
- Банк доторх >
- Банк хооронд >
- Цахим төгрөг >
- Гадаад гуйвуулга >
- Кредит картын төлбөр >
- Зээл төлөх >

Гүйлгээний мэдээлэл

Шилжүүлэх данс

БАНКНЫ АЖИЛЧДЫН ЦАЛИНГИЙН КАРТ
12,000,000 MNT

Хүлээн авах данс

* Дүн
0 MNT

* Гүйлгээний утга

Үргэлжлүүлэх

Өөрийн данс хооронд гүйлгээ хийхэд Шилжүүлэгчийн данс буюу зарлага гарах дансыг сонгоход тухайн дансны боломжит үлдэгдэл харагдана. Хэрэв гүйлгээг загвар болгон хадгалах бол Гүйлгээний загвар болгон хадгалах сонголтыг хийнэ.

ТӨРИЙН БАНК ДОТОР

Гүйлгээ

Гүйлгээний төрөл

- Өөрийн данс хооронд >
- Банк доторх >
- Банк хооронд >
- Цахим төгрөг >
- Гадаад гуйвуулга >
- Кредит картын төлбөр >
- Зээл төлөх >
- Гүйлгээний загварууд >

Гүйлгээний мэдээлэл

Шилжүүлэх данс сонгох

БАНКНЫ АЖИЛЧДЫН ЦАЛИНГИЙН КАРТ
340,000,000 12,099,970.00 MNT

* Хүлээн авах данс

* Хүлээн авагч

* Дүн
0 MNT

* Гүйлгээний утга

Үргэлжлүүлэх

Төрийн банк дотох гүйлгээ хийж байгаа тохиолдолд хүлээн авагчийн дансны дугаарыг оруулахад хүлээн авагчийн нэр автоматаар гарч ирнэ. /Эхний 2 үсэг, сүүлийн 2 үсэг/
Хэрэв гүйлгээг загвар болгон хадгалах бол Гүйлгээний загвар болгон хадгалах сонголтыг хийнэ.

ГАДААД ГҮЙВУУЛГА

Гүйлгээ

Гүйлгээний төрөл

- Өөрийн данс хооронд
- Банк доторх
- Банк хооронд
- Цахим төгрөг
- Гадаад гуйвуулга**
- Кредит картын төлбөр
- Зээл төлөх
- Гүйлгээний загварууд
- Багц гүйлгээ

Гүйлгээний мэдээлэл

Шилжүүлэх данс

БАНКНЫ АЖИЛЧДЫН ЦАЛИНГИЙН КАРТ
3-46 12,09% 3.02 MNT

Гүйлгээний мэдээлэл

* Гүйлгээний дүн
0 USD

* Дүн үсгээр
0

* Хөрвөсөн дүн
0 Хонг. 0

* Улс
Сонгох

* Гүйлгээний утга
Сонгох

* Төлбөрийн зориулалт
Сонгох

* Төлбөрийн дэд зориулалт
Сонгох

Үргэлжлүүлэх

Та Гадаад гуйвуулга илгээхдээ доорх зүйлсийг анхаарах хэрэгтэй. Үүнд:

1. Мөнгөн дүнг зөв оруулж, төлбөрийн зориулалтаа сонгож оруулна.
2. Шилжүүлэгчийн мэдээлэл бөглөнө.
3. Дамжуулагч банкны мэдээлэл

Та дамжуулагч банктай бол энэ хэсгийг бөглөнө.

4. Хүлээн авагч банкны мэдээлэл

Та энэ хэсэгт хүлээн авагч банкныхаа мэдээллийг оруулна.

5. Хүлээн авагчийн мэдээлэл

Та мөнгө хүлээн авах хүнийхээ мэдээллийг тодорхой оруулна. Мөн дамжуулагч банкны шимтгэл төлөх эсэх сонгоно.

Гүйлгээ

Гүйлгээний төрөл

- Өөрийн данс хооронд
- Банк доторх
- Банк хооронд
- Цахим төгрөг
- Гадаад гуйвуулга**
- Кредит картын төлбөр
- Зээл төлөх
- Гүйлгээний загварууд
- Багц гүйлгээ

Гүйлгээний мэдээлэл

Шилжүүлэгчийн мэдээлэл

* Шилжүүлэгчийн нэр

* Регистрийн дугаар

* Утасны дугаар

* Хаяг

Тайлбар: Та гадаад гуйвуулга илгээхдээ SWIFT кодоор хийх бөгөөд доорх зүйлсийг анхаарна уу Мөнгө угаах үйл ажиллагааны эсрэг хууль тогтоомжийн -Гуйвуулагчийн нэр, хаяг, утасны дугаар регистрийн дугаар бүрэн бичигдсэн байх -Гуйвуулгын төлбөрийн зориулалт тодорхой байх.

Үргэлжлүүлэх

БАГЦ ГҮЙЛГЭЭ

Гүйлгээ

Гүйлгээний төрөл

- Өөрийн данс хооронд >
- Банк доторх >
- Банк хооронд >
- Цахим төгрөг >
- Гадаад гуйвуулга >

Гүйлгээний мэдээлэл

То Банкнаас өгөгдсөн загварын дагуу файл байлгасан байх шаардлагатай ба загварыг (0) татаж авна уу. Дэхин гүйлгээ хийхдээ өөрчлөх татаж авсан файлаа өсчихөх боломжтой.

Файл

Файл хуулах

Хуулах

1. Багц гүйлгээ хийх загвар файлыг ЭНДЭЭС татаж авна.
2. Тухайн файлаа зааврын дагуу бөглөөд компьютер дээрээ хадгална.
3. Хадгалсан файлаа Choose File товч даран Гялс банкуугаа хуулна.

КРЕДИТ КАРТЫН ТӨЛБӨР ТӨЛӨХ

Гүйлгээ

Гүйлгээний төрөл

- Өөрийн данс хооронд >
- Банк доторх >
- Банк хооронд >
- Цахим төгрөг >
- Гадаад гуйвуулга >
- Кредит картын төлбөр >**
- Зээл төлөх >

Гүйлгээний мэдээлэл

Хүлээн авах данс

Хүлээн авах данс

* Дүн

0 MNT

Шилжүүлэх данс сонгох

БАНКНЫ АЖИЛЧДЫН ЦАЛИНГИЙН КАРТ
340004128446 12,099977,860,333.0...

* Гүйлгээний утга

Үргэлжлүүлэх

Төлбөр төлөх кредит дансаа сонгоно

Кредит картын зээлд төлөх дүнгээ оруулна

Зээл төлөх дансны дугаарыг сонгоно


Та мэдээллээ бүрэн шалгасны дараа ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ товчийг дарж, нэвтрэх үеийн нууц үгээ оруулснаар гүйлгээ амжилттай хийгдэнэ.

ГҮЙЛГЭЭНИЙ ЗАГВАР

ЗАГВАРЫН НЭР	ШИЛЖҮҮЛЭХ ДАНС	ХҮЛЭЭН АВАХ ДАНС	ДҮН	ГҮЙЛГЭЭНИЙ УТГА
test	MN25003[REDACTED]8446	MN06C[REDACTED]1390704	10,000,000 MNT	test
hnn	MN25003[REDACTED]8446	MN4BC[REDACTED]00365304	1 MNT	test


Тухайн нэг гүйлгээг загвар болгон хадгалах, хадгалсан загвараа дахин гүйлгээ хийхдээ ашиглах боломжтой.

КАРТ




Карт цэсийг сонгосноор танд биетээр байгаа картуудын мэдээлэл харах болон виртуал карт үүсгэж боломжтой.

КАРТЫН ДЭЛГЭРЭНГҮЙ




Та өөрт байгаа бүртгэлтэй карт дээр дарснаар картын дэлгэрэнгүй хэсэгт Хуулга харах, Картын ПИН код солих, төлөв өөрчлөх сонголтуудыг хийх боломжтой байна.

КАРТЫН ТӨЛӨВ ӨӨРЧЛӨХ




Харилцагч та карт цэсээр хандан төлөв өөрчлөх картаа сонгон картын төлөв өөрчлөх боломжтой. Картаа нээх хаах боломжтой юм.

ИНТЕРНЭТ ПИН КОД АВАХ, ПИН КОД АВАХ



Харилцагч та энэ цэсээр интернэт пин код авах боломжтой юм. Интернэт пин код нь картаа ашиглан интернэтээр худалдан авалт хийх, төлбөр төлөхөд ашиглагдах нууцлал бүхий код юм.

КАРТ ШИНЭЭР ЗАХИАЛАХ




Карт цэсийг сонгосноор та өөрийн данс дээр шинээр болон өөрт байгаа картаа захиалах боломжтой.

Шинээр захиалах

* Картын брэнд
VISA VISA

* Картын төрөл
ОУ-ын Хосолсон валюттай Алтан карт



Олон улс болон дотоодад төлбөр тооцоонд ашиглагдах, харилцагчийн нэр төрийн баталгааг илэрхийлэх, картын үйлчилгээний тасгай нөхцөлтэй, картын нууцлал, аюулгүй байдлын олон улсын стандартад нийцсэн EMV, Paywave чип бүхий нэг картанд төгрөг болон ам.долларын данс халбуулан ашиглах боломжтой дебит карт юм.

Картын нөхцөл	Шингэл	Хугацаа	Валют
	50000₮	4 жил	CNY,,PY,MNT,USD

* Данс
[Bank Card Icon]

* Данс
[Bank Card Icon]

* Картан дээр хэвлэгдэх нэр
[Input field]

Хаягийн мэдээлэл

* Карт авах төрөл
Сонгох

Хаягийн төрөл
Сонгох

* Дүүрэг
Сонгох

* Хоргоо
Сонгох


* Дэлгэрэнгүй хаяг
[Input field]

Үргэлжлүүлэх

Карт шинээр захиалах үед та картын брэндээ сонгож тухайн брэнд дээр гарах боломжит бүтээгдэхүүний төрлөө сонгож карт захиалах дансаа сонгон хүсэлтээ илгээнэ.

Та Гялсбанкаар карт захиалах бол шуудангаар картаа хүргүүлэн аваарай.

ВИРТУАЛ КАРТ ҮҮСГЭХ




Үүсгэх товчоор дамжуулан та өөрийн данс дээрээ виртуал VISA карт үүсгэх боломжтой.

Виртуал картын хугацаа нь 1 сар, 3 сар, 6 сар, 12 сарын сонголттой ба та өөрт тохирох хугацаагаар сонгон үүсгэх боломжтой.

Нууц үгээ оруулснаар Виртуал карт амжилттай үүснэ.

Анхааруулга: Виртуал карт нь зөвхөн интернэт худалдан авалт хийхэд зориулагдсан биет бус карт ба нэг харилцагч дээд тал нь 3 виртуал карт үүсгэх боломжтой болохыг анхаарна уу.


ТӨЛБӨР




Төлбөр цэсээр дамжуулан хэрэглээний төлбөрөө төлөх, гар утасны төлбөр, СУИС төлбөр болон бусад төлбөр төлөх боломжтой.

Мөн хаягаар, хэрэглэгчийн кодоор, цахилгааны кодоор, Юнивишн, Скаймедиа болон биллер байгууллагын кодыг ашиглан хайлт хийх, төлбөр төлөх, холбох боломжтой.

ХЭРЭГЛЭЭНИЙ ТӨЛБӨР




Энэ цэсээр таны холбосон бүх нэхэмжлэлийн жагсаалт харагдана. Мөн хэрэглээний төлбөр хайх, холбох товч дээр дарж хэдэн ч байр холбох боломжтой.



Хайх цэсээр та хаягаар, хэрэглэгчийн кодоор, цахилгааны кодоор, Юнивишн, Скаймедиа болон биллер байгууллагын кодыг ашиглан хайлт хийх, төлбөр төлөх, холбох боломжтой.


ГАР УТАСНЫ ТӨЛБӨР, НЭГЖ



Та өөрийн болон бусдын утасны дугаарыг нэгжийн картаар цэнэглэх, ярианы төлбөр төлөх, дата авах боломжтой.


Таны төлбөр 24/7 зарчмаар онлайнгаар хийгдэнэ. Хэрэв та Скайтел ХХК-ны дилер бол Скайдилер цэсээр дансаа цэнэглэх боломжтой.

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ




Төлбөр цэсний Төрийн үйлчилгээ цэсээр дамжуулан Нийгмийн даатгал, Гаалийн төлбөр, Торгууль болон Татвар төлөх боломжтой.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ




Та өөрийн болон бусдын Нийгмийн даатгалын үйлчилгээний Сайн дурын даатгал, Эрүүл мэндийн даатгал болон Лавлагааны хураамжаа төлөх боломжтой. Та гүйлгээ хийхдээ Даатгуулагчийн мэдээллийг үнэн зөв оруулаарай.

ГААЛИЙН ТӨЛБӨР ТӨЛӨХ




Харилцагч та энэ цэсээр гаалийн төлбөр төлөх бол Гаалийн байцаагчаас нэхэмжлэх бүхий хуудас авсан байна. Нэхэмжлэх дээрх дугаарыг хайлтын хэсэгт оруулснаар Таны төлөх гаалийн төлбөр, хураамжийн мэдээллийг харуулна. Таныг гаалийн төлбөр, хураамжаа төлсөн даруй гүйлгээ хийсэн тухай мэдээлэл ГЕГ-ын системд шууд илгээгдэнэ.

ТОРГУУЛЬ ТӨЛӨХ



Та Торгууль төлөх цэсийг ашигласнаар ЗХУТ болон ЦЕГ-Замын цагдаагаас оногдуулсан торгуулийн төлбөрийг тээврийн хэрэгслийнхээ улсын дугаараар хайлт хийж төлөх болон нэг дор 10 хүртэлх торгуулийн төлбөрийг илүү хялбараар төлөх боломжтой.


ТАТВАР ТӨЛӨХ



Харилцагч та бүх төрлийн татвараа нэхэмжлэхийн дугаар болон хөрөнгийн бүртгэлийн дугаараар хайлт хийж онлайнгаар төлөх боломжтой.


Хэрэв та тээврийн хэрэгслийн татвар төлөх бол Хайлт хийх төрлийн Хөрөнгийн бүртгэлийн дугаар хэсэгт тээврийн хэрэгслийн улсын дугаараа оруулан төлөх боломжтой.

БУСАД ТӨЛБӨР



Та өөрийн болон бусдын кабелийн төлбөр болон интернэтийн төлбөрийг төлөх боломжтой.


ЗЭЭЛ



Үндсэн нүүр дэлгэц дээрх Зээл цэсийг сонгоно. Зээл цэсэнд таны авсан бүх зээлийн үлдэгдэл болон цахимаар хүсэлт илгээн авах боломжтой зээлийн төрлүүд харагдана. Үүнд:

- Хадгаламж барьцаалсан зээл
- Гялс зээл
- Цалингийн зээл
- Тэтгэврийн зээл
- ПОС-ын орлого барьцаалсан зээл

ЗЭЭЛИЙН ТӨЛБӨР ТӨЛӨХ



Та зээлийн төлбөр төлөх бол Зээл цэснээс төлөх зээлийн дансаа сонгон Зээлийн дэлгэрэнгүй хэсгээс Төлөлт хийх товчийг дарна.

Зээлийн төлбөр төлөх дансаа сонгож төлөх дүнгээ оруулан үргэжлүүлэн баталгаажуулалт хийснээр зээлийн төлбөр төлөлт амжилттай хийгдэнэ.

ЗЭЭЛИЙН ТӨЛБӨРИЙН ХУВААРЬ

Зээлийн дансны дэлгэрэнгүй

ХАДГАЛАМЖ БАРЬЦААЛСАН ОНЛАЙН ЗЭЭЛ /МНТ/
MN21000 7537

Улдгагдал
0.00 MNT

Төлбөрийн хуваарь

Зээлийн хэмжээ 150,000 MNT

Нийт төлсөн 0 MNT

Төлөлт хийх өдөр 2024-08-03 Жилийн хүү 16%

Эхлэх огноо 2023-02-26 Дуусах огноо 2024-08-03

Хуулга харгах Төлөлт хийх

Сүүлийн гүйлгээ

Та Зээлийн дэлгэрэнгүй хэсэг дэх Төлбөрийн хуваарь товчийг дарснаар таны төлөлт хийх хуваарь харагдана.

ХАДГАЛАМЖ БАРЬЦААЛСАН ЗЭЭЛ

Хадгаламж барьцаалсан зээл

Хадгаламжийн данс

ИРГЭДИЙН ХУГ-ТАЙ ХАД-Ж 370-730 ХОНОГ
102301863225 2,633,286.04 MNT

* Зээлийн боломжит дээд хэмжээ
0

* Хүсн буй зээлийн хэмжээ
0

* Зээлийн хүү
%

* Зээл эргүүлж төлөх өдөр

* Зээлийн хугацаа /хонгоор/

* Бодогдох хүү
0.00

* Өргөдлийн хураангуй
0.00

Зээл олгох данс

Үргэлжлүүлэх

ТӨРИЙН БАНК

Сайн байна уу? ЭРДЭМБЭРЭН

Зээл

Зээлийн төрлүүд

Хадгаламж барьцаалсан зээл

Тэтгэвэрийн цохим зээл

Та Хадгаламж барьцаалсан зээл авах бол Зээл цэсэнд хандан хүсэлт илгээх мөн хадгаламжийн дансны дэлгэрэнгүй хэсгээс зээл авах цэсийг сонгож зээлийн хүсэлтээ оруулах боломжтой.

Таны авах боломжит зээлийн үлдэгдэл гарах ба үргэжлүүлэх товч дарж зээл авах дүнгээ оруулан баталгаажуулснаар зээл олголт амжилттай хийгдэнэ.

ЦАХИМ ЗЭЭЛ

Зээл

Зээлийн төрлүүд

- Хадгаламж барьцаалсан зээл >
- Гялс зээл >**
- Цалингийн цахим зээл >
- Тэтгэвэрийн цахим зээл >
- ПОС-ын орлого барьцаалсан цахим зээл >

Та Зээл цэснээс цахимаар авах бүтээгдэхүүнээ сонгон Шинэ зээлийн хүсэлт гаргах товчийг дарж үргэжлүүлнэ.

Та цахим зээлүүдийн ерөнхий шаардлагыг хангасан тохиолдолд хүсэлт илгээх боломжтой.

Зээлийн лавлагааг ХУРДАН систем ашиглан банканд илгээх ба таны Emongolia-д бүртгэлтэй гар утасны дугаарт нэг удаагийн нууц код илгээгднэ.

Та хүсэлт илгээхдээ GSign /тоон гарын үсэг/ ашиглаж зээлийн гэрээг онлайнар байгуулж зээл авах боломжтой.

Гялс зээл

Ерөнхий мэдээлэл

Харилцагч үйлчилгээний ерөнхий гэрээ байгуулсан эсэх

Тийм

Гялс зээлгүй эсэх

Тийм

Бүртгэлтэй имэйл хаяг

ER-NE@GMAIL.COM

Үргэлжлүүлэх

Шаардлага

Зээл хүсэгч би Зээлийн мэдээллийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өгөхийг банканд үүгээр зөвшөөрч байна.

- Иргэний үнэмлэхийн лавлагаа
- Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа
- Зээлийн мэдээллийн сангийн лавлагаа

Зээлдэгчид тавигдах шаардлага:

- 18 насанд хүрсэн,иргэний эрх зүйн бүрэн чадамжтай байх.
- Монголбанкны хэрэглээний зээлийн өр,орлогын харьцаа тооцох журмын дагуу баталгаажуулах боломжтой цалин,түүнтэй адилхан тогтмол орлого татварын дараах орлогын 60 хувийг хэрэглээний дүнгээр зээл,зээлийн хүүг хувиарийн дагуу эргүүлэн төлөх чадвартай байх.
- Ангилалдсан зээлийн үлдэгдэлгүй,чанаргүй зээлийн түүхгүй байх.
- Гялсбанкны эрхтэй,зээлийн гүйлгээ болон төлбөрийн мэдээллийг хүлээн авах хувийн цахим шуудангийн хаягтай байх.
- Төрийн банканд Гялс зээлийн үлдэгдэлгүй байх.
- Тоон гарын үсэг авсан байх байх.

Таны сонгосон зээлийн бүтээгдэхүүний цахимаар олгох хэмжээ болон мэдээллүүд гарах ба та хүсэж буй зээлийн хэмжээ болон өөрийн мэдээллүүдээ оруулан хүсэлтээ илгээнэ.

Гялс зээл


Зээлийн түүх

Бүтээгдэхүүн	Зээлийн хэмжээ	Огноо	Төлөв
Гялс цахим зээл	225,400.00	2023-05-19T12:49:34	Хүчинтэй хугацаа дууссан
Гялс цахим зээл	2,470,000.00	2023-05-19T12:47:51	Хүлээгдэж байгаа
Гялс цахим зээл	500,000.00	2023-05-19T12:45:53	Харилцагч цуцалсан
Гялс цахим зээл	2,000,000.00	2023-05-19T12:35:46	Шаардлага хангаагүй
Гялс цахим зээл	250,000.00	2023-05-10T11:33:37	Хүчинтэй хугацаа дууссан
Гялс цахим зээл	2,900,000.00	2023-05-03T09:38:51	Зээл олгогдсон
Гялс цахим зээл	29999999	2023-05-02T15:29:14	Харилцагч цуцалсан

Хүсэлт илгээснээр тухайн зээлийг сонгох үед таны хүсэлт шийдвэрлэгдсэн эсэх талаарх мэдээлэл харэгдана.

Та илгээсэн зээлийн хүсэлтээ цуцлах боломжтой.

БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ



Бусад цэсний Бусад үйлчилгээ дэд цэсийг ашиглан та гүйлгээний лимит нэмэх, хувийн дугаар авах, мессеж мэдээ үйлчилгээнд бүртгүүлэх, Монголбанкны дансны нэгдсэн санд бүртгүүлэх, захиалгат шилжүүлэг үйлчилгээнд бүртгүүлэх, автомат хуримтлал үйлчилгээнд бүртгүүлэх, арилжааны хэлцэл хийх болон даатгалын мэдээлэл харах боломжтой.

ГҮЙЛГЭЭНИЙ ЛИМИТ

Гүйлгээний лимит

+ Гүйлгээний лимит нэмэх хүсэлт

данс	лимит	төлөв	огноо	
MN6600...1855960	15,000.00 USD	Хүлээгдсэн	2023-11-21 13:53:34	
MN6600...1855960	5,000,000.00 USD	Хүлээгдсэн	2023-11-21 13:52:45	
MN3900...1390692	100,000,000.00 MNT	Хүлээгдсэн	2023-08-07 18:12:01	
MN2500...4128446	100,000,000.00 MNT	Хүлээгдсэн	2023-07-24 15:40:20	
MN0800...1853318	100,000,000.00 MNT	Цуцалсан	2022-12-23 16:19:31	

Та энэхүү цэсээр дамжуулан өдрийн гүйлгээний лимитээ 100 сая төгрөг хүртэл нэмэх хүсэлт илгээх боломжтой.

Лимит нэмэх дансаа сонгон нэмэх лимитийн дүнгээ оруулан хүсэлтээ илгээнэ.

ХУВИЙН ДУГААР АВАХ ҮЙЛЧИЛГЭЭ

Сайн байна уу? ЭР/ЭЭН РЭН

Холбоот санал

Хувийн дугаар

Хувийн дугаар үйлчилгээ

Та 3 нуртал дансны дугаар дээр тус үйлчилгээг авах боломжтой. Хувийн дугаар үйлчилгээ нь 4-8 оронтой дугаарыг дансны дугаарын оронд ашиглан гүйлгээ хийх боломжтой Төрийн банкны дэвшилтэт үйлчилгээ юм. Та дансны дугаарын оронд ашиглагдах Хувийн дугаараар хүссэн дугаараа сонгох боломжтой. Жишээ - төрсөн он сар өдөр - утасны дугаар, - авто машины дугаар гэх мэт.

Та Хувийн дугаар үйлчилгээг ашиглан дараах сувгуудаар шилжүүлэг хийх боломжтой. Үүнд:

- Гялсбанк үйлчилгээгээр
- Төрийн банкны АТМ-оос
- Төрийн банкны сансар нэгжүүдээс

Мөнгө шилжүүлэгч нь Гялсбанк үйлчилгээ болон Төрийн банкны АТМ ашиглан таны Хувийн дугаараар мөнгө шилжүүлэхэд бүртгүүлсэн гар утсанд шилжүүлгийн мэдээллийг мессежээр үнэггүй илгээнэ.

+ Хувийн дугаар нэмэх

ХУВИЙН ДУГААР	ДАНС	ТӨЛӨӨ
09	MN840034	Нээлттэй
95	MN250034	Нээлттэй
95	MN250034	Хаагдсан

Та Хувийн дугаар авах утасны дугаар болон дансны дугаар сонгоно. Таны оруулсан гар утсанд Хувийн дугаараар гүйлгээ хийгдсэн даруйд мессежээр мэдээлэл илгээгдэнэ. Та 3 хүртэлх Хувийн дугаар авах боломжтой.

МЭССЕЖ МЭДЭЭ

Сайн байна уу? ЭР/ЭЭН РЭН

Мессеж үйлчилгээ

* Утасны дугаар


* Шинтгэл төлөх данс

Үргэлжлүүлэх

1. Мессеж мэдээ хүлээн авах гар утасны дугаараа оруулна.
2. Үйлчилгээнд бүртгэх дансны дугаарын ард байрлах бүртгэх товч дээр дарна.
3. Та гүйлгээний төрлөө сонгож, мэдээ хүлээн авах лимитээ оруулна.
4. Идэвхжүүлэх сонгож үргэлжлүүлэх товч дарна.
5. Үйлчилгээний бүртгэлээ Гялсбанкны гүйлгээ хийх нууц үгээр баталгаажуулснаар бүртгэл дуусна.


ЗАХИАЛГАТ ШИЛЖҮҮЛЭГ

БҮРТГЭЛТЭЙ БАЙГАА ЗАХИАЛГАТ ШИЛЖҮҮЛЭГ ХАРАХ



Дансаа сонгон харах товч дарахад тухайн дансанд бүртгэлтэй байгаа захиалгат шилжүүлгийн жагсаалт гарна. Та Дэлгэрэнгүй товч дарж мэдээлэл харах, Засах, цуцлах товч дарснаар мөнгөн дүн, давтамж, данс зэргээ өөрчлөх, идэвхигүй төлөвт шилжүүлж цуцлах боломжтой.

ШИНЭЭР ЗАХИАЛГАТ ШИЛЖҮҮЛЭГ ҮҮСГЭХ



Тухайн гүйлгээг нэг удаа хийх бол ажиллах огноо талбарт гүйлгээ хийгдэх огноог сонгоно. Харин олон давтамжтай хийгдэх гүйлгээний хувьд: Огноо талбарт захиалгат шилжүүлэг үйлчилгээний үргэлжлэх хугацааг оруулна. Захиалгат шилжүүлэг баталгаажуулахад гүйлгээний мөнгөн дүнгээс үл хамааран нэг удаагийн нууц үг ашиглана.

АРИЛЖААНЫ ХЭЛЦЭЛ

Та тухайн өдрийн зөвшөөрөлгүй арилжаа хийх лимитээс хэтэрсэн дүнгээр арилжаа хийх гэж буй тохиолдолд АРИЛЖААНЫ ХЭЛЦЭЛ ХИЙХ цэсээр арилжаа хийх боломжтой.

Арилжааны хэлцэл

+ Арилжааны хүсэлт илгээх

ТӨРӨЛ	ХҮЛЭЭН АВАХ ДАНС	ДҮН	ТӨЛӨВ	ОГНОО	
Авах	MN250030000004128446	10,000.00 USD	Хүсэлт илгээсэн (Харилцагч)	2023-08-11 11:56:33	
Авах	MN89003000000400740	16,000,000.00 USD	Хүсэлт илгээсэн (Харилцагч)	2023-06-23 17:09:36	

Арилжааны хэлцэл/Валют авах/

Арилжааны хэлцэл ⓘ

— Хүлээн авагч

* Хаана авах

* Валют

* Хүлээн авах данс

* Дүн

— Төлбөр хийх

* Валют


* Дансны дугаар

* Утасны дугаар

Арилжааны хүсэлт илгээх товч дээр дарсанаар дараах цонх гарч ирэх бөгөөд уг цонхонд арилжааны мэдээллийг оруулна. /Энэ тохиолдолд арилжааны лимит 20 сая төгрөг байгааг доорх анхааруулах бичигт харуулж байна./

Та гадаад валют банкнаас худалдан авах эсвэл банканд худалдах эсэхээ хамгийн эхний талбараас сонгох бөгөөд тухайн талбарыг хэрхэн сонгосноор дараагийн талбар өөрчлөгддөг болохыг анхаарна уу.

ДАНСНЫ НЭГДСЭН САНД БҮРТГҮҮЛЭХ



ТӨРИЙН БАНК

Гүйлгээ

Нүүр

Данс

Карт

Төлбөр 4

Зээл

Санхүү

Бусад

Сайн байна уу? ЭРД ҮРЭН

Дансны нэгдсэн сан


* Дансны дугаар:

Та энэхүү цэсээр дамжуулан Монголбанкны Дансны нэгдсэн санд өөрийн дансыг бүртгүүлснээр Банк хоорондын гүйлгээг хүлээн авахад хялбар болно.

Бүртгүүлэх сонголт нь Гар утасны дугаар, утас, мэйл болон бусад утга оруулан бүртгүүлэх боломжтой.

ДААТГАЛЫН МЭДЭЭЛЭЛ

Даатгалын мэдээлэл



Төрийн банк нь нь Банкны тухай хууль болон Даатгалын мэргэжлийн орлолцогчийн тухай хуулийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны 2013.09.18-ны өдрийн 296 тоот тогтоолоор "ДААТГАЛЫН ЗУУЧЛАЛ"-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авч Даатгалын зуучлалын үйл ажиллагаагаа явуулж байна.

Бид даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг улам боловсронгуй болгож, харилцагч нартаа улам ойртсоор байна.

Та Төрийн банкны вэб сайтаар дамжуулан манай банктэй хамтран ажиллаж буй даатгалын компаниудын 30 гаруй нэр төрлийн даатгалын бүтээгдэхүүнээс сонголт хийж хүсэлтээ илгээснээр өөрийн сонгосон Төрийн банкны салбар, нэгж дээр бичиг баримтайгаа очин даатгалын гэрээг баталгаажуулан авч өөрт учирч болох санхүүгийн эрсдэлээ даатгуулах, үнэт цагаа хэмнэх боломжтой.


+ Даатгал хийлгэх

ГЭРЭЭНИЙ ДУГААР	ДААТГАЛЫН НЭР	ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН	ДААТГАЛЫН КОМПАНИ
173400-0005	Зээл-Цалингийн зээлийн эрсдэлийн даатгал	16,000,000.00	"Бодь даатгал" ХХК
213400-0006		1,000,000.00	"Ард даатгал" ХК
233499-0002	Монгол гэрийн даатгал	1,500,000.00	"МИГ даатгал" ХХК

Төрийн банкны даатгалын зуучлалын үйлчилгээ авсан бол энэхүү цэсээр дамжуулан танд даатгалын мэдээлэл харагдана.

Нэмэх товчийг дарснаар онлайн даатгалын үйлчилгээний дэлгэцэнд шилжин хүсэлт илгээх боломжтой.

ТУСЛАМЖ



Тусламж цэсээр дамжуулан та валютын ханш, тооцоолуур, салбарын байршил, IBAN дугаар хайх, лавлах, санал хүсэлт, холбоо барих мэдээллүүдийг авах боломжтой.

ВАЛЮТЫН ХАНШ

Валютын ханш цэсээр дамжуулан та бэлэн болон бэлэн бус валютыг авах, зарах ханшаар харах боломжтой.


Валютын ханш

Бэлэн Бэлэн бус


Валют	Валютын нэр	Албан	buy	Зарах
MNT	МОНГОЛ ТӨГРӨГ	1	1	1
USD	АМЕРИК ДОЛЛАР	3,454.46	3,450	3,477
EUR	ЕВРОПЫН ХОЛБОО ЕВРО	3,635.13	3,438	3,646
CNY	ХЯТАД ЮАНЬ	473.49	464.5	481.4
JPY	ЯПОН ЙЕН	23.16	23.13	24.94
RUB	ОХУ РУБЛЬ	34.22	31.04	74.16
GBP	АНГЛИ ФУНТ	4,204.25	3,909	4,217
KRW	ӨМНӨД СОЛОНГОС ВОН	2.55	2.42	2.61
AUD	АВСТРАЛИ ДОЛЛАР	2,339.37	0	0
CHF	ШВЕЙЦАР ФРАНК	3,788.2	0	0
CAD	КАНАД ДОЛЛАР	2,195.31	0	0

ЛАВЛАХ

Лавлах цэсээр дамжуулан та үйлчилгээний нөхцөл, гадаад гуйвуулгын шимтгэл, түгээмэл асуулт, хариулт, нууцлалын бодлого, аюулгүй байдлын зөвлөмж, гарын авлагатай танилцах болон вэб хаягт зочлох боломжтой.




САНАЛ ХҮСЭЛТ



Та Гялсбанкны талаар болон Төрийн банканд санал хүсэлтээ энэхүү цэсээр дамжуулан илгээх боломжтой.

ХОЛБОО БАРИХ



Та Төрийн банкны лавлах утас, и-мэйл хаягт холбогдох мөн банкны вэбд зочлох бол энэхүү цэсээр дамжин орох боломжтой.

➤ ГЯЛСБАНК ҮЙЛЧИЛГЭЭНД БҮРТГҮҮЛЭХ

Харилцагч та Төрийн банкны салбарт нэг л удаа иргэний үнэмлэхтэйгээ ирж Гялсбанк үйлчилгээнд бүртгүүлснээр **ТАНЫ БАНК ТАНЫ ГАРТ** очно.

Дэлгэрэнгүй мэдээллийг:
1800-1881 лавлах утсаар лавлана уу.



ТӨРИЙН БАНК

ЭРСДЭЛГҮЙ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА

☎ 1800-1881

🌐 www.statebank.mn

📘 /StatebankMN

📺 /StatebankMN